



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/682

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл балансаас  
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянзүрх дүүргийн “Баянзүрх эко тохижилт, үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй нийт 224,575,000 (хоёр зуун хорин дөрвөн сая таван зуун далан таван мянга) төгрөгийн балансын үнэ, 181,978,125 (нэг зуун наян нэгэн сая есөн зуун далан найман мянга нэг зуун хорин тав) төгрөгийн үлдэх өртөг бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн “Баянзүрх эко тохижилт, үйлчилгээ” ОНӨААТҮГ (Ж.Батболд)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирж буй хавсралтад заасан тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Баянзүрх дүүргийн “Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төв” ОНӨААТҮГ (Б.Бямбажаргал)-т үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110203172



БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

Д/д	Эд хөрөнгийн нэр	Улсын дугаар	Арлын дугаар	Ашиглалтад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	Бага оврын ачааны машин /Киа Бонго-3/	07-65 УНД	KN3HAP8N27 K246157	2018	16,600,000	16,600,000	-	Баянзүрх дүүргийн "Хөрөнгө	Баянзүрх дүүргийн "Хөрөнгө
2	Авто ачигч трактор /XCMG.WZ30-25/	27-04 УР	2022483	2022	207,975,000	25,996,875	181,978,125	Тохижилт, "Баянзүрх эко үйлчилгээ" ОНӨААТҮГ	оруулалт, бүтээн байгуулалтын төв" ОНӨААТҮГ
	Шилжүүлэх хөрөнгийн нийт дүн							181,978,125	